

“САНУУЛ БАЯН УУЛ-
АУДИТ” ХХК

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

Аудитын тайлан

Нэмэлтмэдээлэл авахыг хүсвэл
доорх хаягаар харилцана уу:

Захирал Б.Шатар
Утас: 89383852
Цахим хаяг: baldandorjshatar@yahoo.com

Гэрээт аудитор Д.Оюунбат
Утас: 89585807
Цахим хаяг: oyuna200702@yahoo.com

Хаяг:
Дундговь аймаг Сайнцагаан сум 7 дугаар
баг

АГУУЛГА

ХУУДАС

- Аудитын гэрчилгээ
- Менежментийн захидал
- Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	Error! Bookmark not defined.
2	Аудитын тайлан.....	2
2.1	Оршил.....	2
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	2
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	3
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	3
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	4
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	4
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	5
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	6
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	Error! Bookmark not defined.
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал .	
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.12	Шилэн дансны мэдээлэл	9
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	20
3.1	<u>«management zurchil1»</u>	
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	Error! Bookmark not defined.
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	Error! Bookmark not defined.
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	Error! Bookmark not defined.
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	Error! Bookmark not defined.
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	Error! Bookmark not defined.

1 Аудитын тайлан

1.1 Оршил

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын төсвийн захирагч Ч.Отгонсүрэнд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын 2017 оны санхүүгийн тайланг баталгаажуулах аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго юм.

Төсвийн захирагч нь санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго юм.

Тус газар нь 2017 оны санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01/38 дугаартай албан бичгээр хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

Аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25-наас 2018 оны 02 дугаар сарын 10-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 21-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, гэрээт аудитор Д.Оюунбат хариуцаж хэрэгжүүлэв.

1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж–Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000-1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

1.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

2017 онд Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь дараах зорилтуудыг дэвшүүлсэн ажилласан байна. Үүнд:

- I. Мэргэжлийн чадварлаг боловсон хүчний багийг бүрдүүлэх, тэдний ажиллах таатай орчин материаллаг баазыг бэхжүүлэх,
- II. Талын генетик нөөцийг хамгаалах сайжруулах, үржлийн малыг шилэн сонгох, үүлдэр, омгийн малд хянан магадлагаа хийх, баталгаажуулах, мал сүргийг эрсдэлээс хамгаалах, бэлчээрийг хамгаалах, сайжруулах, тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах,
- III. Малын эрүүл мэндийг хамгаалах, мал амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тайван нөхцлийг баталгаажуулах,
- IV. Газар тариаланг хөгжүүлэх, түүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх,
- V. Хүн амыг эрүүл баталгаат хүнсээр хангах, хүнсний хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх,
- VI. Жижиг дунд үйлдвэрийг шинээр бий болгох, хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх,
- VII. Салбарын үйлдвэрлэлд шинэ, дэвшилтэт технологи, инноваци болон кластерийг нэвтрүүлэх, нутагшуулах,
- VIII. Био аюулгүйн 2 дугаар зэрэглэлийг хангасан СУАЦЛ-той болох, итгэмжлэлд хамрагдах гэсэн зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ.

Тус байгууллагын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараахь хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- ХХОАТ-ын тухай хууль
- НД-ын тухай хууль

1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь ХХААХҮЯ-аас 2016 онд гаргасан НБББББ-ийг мөрддөг бөгөөд НБББББ нь салбарын онцлогт тохирсон байна.

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Тус газар нь санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашиглаж байна.

Санхүүгийн програмд Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлж шинэчлэлт өөрчлөлтүүдийг тухай бүр хийлгэсэн байна.

1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулья.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн тодорхойлсон уламжлалт болон

хяналтын эрсдэлийн дагуу горим хэрэгжүүлэн тэдгээрийг ТАБ-СТА-АБ.1-АБ.8 маягтуудаар баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 5 асуудал эрсдэл өндөр гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд зайлшгүй шалгах эрсдэлтэй 5 асуудалд аудитыг чиглүүлэн, аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

1.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ийн дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь орлогын дүнд тухайн байгууллагын үйл ажилагаанд зарцуулагддаггүй орлого тооцогдох магадлалтай бөгөөд нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгийн дүн бага байгаа тул нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зүйтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн үеийн материаллаг байдлын түвшинг үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 758,965.9 мянган төгрөгөөс 0.5% буюу 3,794.8 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлын түвшинд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэж /ТАБ-СТА-В-1/ маягтаар баталгаажууллаа.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 0.5%-иар тооцсон нь сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлангийн аудитаар 2 жилд нь "зөрчилгүй", 1 жилд нь "итгэл" үзүүлсэнтэй холбоотой юм.

Гүйцэтгэлийн явцад шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илрээгүй.

1.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын төлөвлөлтөөр нийт 8 дансанд эрсдэлтэй гэж тооцож, горим, сорил хэрэгжүүлэх явцад 5 дансанд алдаа зөрчил илрээгүй тул нарийвчилсан горим сорил хийгдээгүй бөгөөд зөрчилтэй гэж үзсэн 3 дансанд нарийвчилсэн горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баталгаажуулав. /ТАБ-СТА-В.3.1-В.3.3/, /ТАБ-СТА-В.3.9/

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах

боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дахь залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараахь байдлаар ангилав.

(мянган төгрөгөөр)				
№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	2	492.1	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	331.7	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Аудитын явцад залруулсан	2	1,111.0	
5	Залруулагдаагүй алдаа	1	.0	
6	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
7	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	5	1,934.8	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг /ТАБ-СТА-В-4.3-4.4/ маягтад нэгтгэн баримтжуулав.

1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хоёр ажилтанд нийт 331.7 мянган төгрөгийн цалинг, ээлжийн амралтын цалинтай давхардуулан олгожээ.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар”-ын 13-т заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ээлжийн амралтын цалинтай давхаруулан олгосон нийт 331.7 мянган төгрөгийн цалинг орон нутгийн орлогод төвлөрүүлэх төлбөрийн акт бичив.

2. Нас дэвшүүлсэн болон худалдсан малын нийт 688.0 мянган төгрөгийг зардлаар тайлагнажээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулах

3. Ажилчдын цалингаас сахилгын арга хэмжээнд нийт 423.0 мянган төгрөг суутгасан боловч суутгалын хэмжээгээр цалингийн зардлыг бууруулж тайлагнажээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулах

4. Цалингийн сангаас 240.0 мянган төгрөгөөр ахмадын хүлээн авалт хийж, зориулалт бусаар зарцуулжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

5. Тарилгын үлдэгдэл болон сав суулгын устгалт, вакцинжуулалтын нотлох баримт хангалтгүй байна. Тухайлбал: Тарилгын үлдэгдэл болон шил савыг устгасан болон сургалт хийсэн тухай зурагжуулалт зарим тайланд байхгүй, тарилга хийсэн тухай актанд зөвлөмж өгөгдөөгүй, туслах ажилтны гарын үсэггүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

6. Аудитын явцад нягтлан бодогчоос ирүүлсэн өргөдлийг шалгаж үзэхэд нягтлан бодогчийн цалинг үндэслэлгүй бууруулж, 2017 онд 252.1 мянган төгрөгийн цалин дутуу олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8, 18 дугаар зүйлийн 18.5, Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтын 7 дахь заалтыг тус тус зөрчсөн байна

7. **Шийдвэрлэсэн нь:** 2017 оны цалингийн зөрүү 252.1 мянган төгрөгийг нягтлан бодогчид нөхөн олгох зөвлөмж өгөх

1.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

- 1.9.1.1 Тайлант хугацаанд хоёр ажилтанд нийт 331.7 мянган төгрөгийн цалинг, ээлжийн амралтын цалинтай давхардуулан олгожээ.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар”-ын 13-т заасныг тус тус зөрчсөн байна.

1.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Албан шаардлага байхгүй

1.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар алдаа зөрчилтэй асуудал гараагүй.**1.9.4 Хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр алдаа зөрчилтэй асуудал гараагүй.****Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл**

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,934.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 1,111.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 331.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, нийт 492.1 мянган төгрөгийн 3 зөвлөмж өглөө.

1.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

1. Анхаарал татсан асуудал байхгүй байна.

1.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-т өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой хөтөлбөр, арга хэмжээн урсгал зардалд зориулан 165,055.8 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	165,055.8	162,640.4	-1,5%	-2,415.4
1.1	Урсгал зардал	165,055.8	162,640.4	-1,5%	-2,415.4
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0	0.0%	0.0
2	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	165,055.8	162,640.4	-1,5%	-2,415.4
2.1	Улсын төсвөөс санхүүжих	163,555.8	161,140.4	-1,5%	-2,415.4
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	1,500.0	1,566.7	4.4%	66.7

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар" нь 2017 онд 165,055.8 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдсан бөгөөд төсвөө 100 % авч, үйл ажиллагааны зардалд 162,640.4 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн хэмнэлт 2,415.4 мянга, төлөвлөгөөнөөс давсан орлого 66.7 мянга, нийт 2,482.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Энэ нь цалин, тогтмол зардлууд хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсвийг нийт дүнгээр хэтрүүлээгүй, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулаагүй байна.

Тус газар нь оны эхэнд өглөггүй, 230.9 мянган төгрөгийн авлагатай байсан ба тайлант хугацаанд авлага 32.5 мянган төгрөгөөр буурчээ. Мөн тайлант хугацаанд 2,850.0 мянган төгрөгийн урьдчилж гарсан зардал бүртгэжээ.

Бараа материалын дансны 2017 оны эхний үлдэгдэл 194,169.3 мянган төгрөг байсан бөгөөд тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 5,758.9 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 296,028.2 мянга, нийт 301,787.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант жилд зарцуулсан 376,963.8 мянга, худалдан борлуулсан 130.0 мянга, малын нас дэвшсэн 558.0 мянга, акталсан 49.0 мянга, нийт 377,700.8 мянган төгрөгөөр хасагдаж, 118,255.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Үндсэн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 607,272.5 мянган төгрөг байсан бөгөөд тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,815.0 мянга, ХХААХҮС-ын 2017 оны А/167 дугаар тушаалаар үнэ төлбөргүй хүлээн авсан 47,379.3 мянга, нийт 48,239.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд Төрийн өмчийн хорооны бодлого зохицуулалтын газрын 2016 оны 346 дугаар тогтоолоор акталсан 3,838.2 мянга, Засгийн газрын 2012 оны 224 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 2012 оны 2/1401 дүгээр тогтоол болон аймгийн Орон сууц хувьчлах товчооны 2012 оны 01 дүгээр тогтоол, 2016 оны хурлын тэмдэглэл, Орон нутгийн өмчийн газрын 2017 оны 332 дугаар албан бичиг, ХХААГ-ын даргын 2017 оны А/26 дугаар тушаалын дагуу хувьчлагдсан 7,091.1 мянга, нийт 10,929.2 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, 644,582.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагджээ.

Тус байгууллагад 2017 онд үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 1,500.0 мянган төгрөгөөр батлагдаж, төлөвлөгөөг 1,566.7 мянган төгрөгөөр биелүүлсэн байна. Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар ХХААХҮЯ-аас 170,121.9 мянга, аймгийн ОНХС-аас 5,000.0 мянга, нийт 175,121.8 мянган төгрөгийг төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр авч зарцуулсан байна.

1.12 Шилэн дансны мэдээлэл

Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэстэй бөгөөд 20 нэр төрлийн мэдээллийг 149 удаа оруулахаас бүрэн оруулж, 100 % хэрэгжүүлсэн байна.

1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайланд Монгол Улсын Ерөнхий аудитор итгэл үзүүлж, “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн тул зөвлөмж өгөгдөөгүй байна.

1.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Говьсүмбэр аймгийн " Хүнс, хөдөө аж ахуйн газар " -ын 2017 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэлээ.

Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын 2017 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж "Зөрчилгүй" санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Хугацаа: 17.12.31

№	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	194,400,158.32	121,303,928.09
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	0.00	-
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	-
9	Төгрөг	0.00	-
10	Төрийн сангийн харилцах	0.00	-
27	АВЛАГА	230,887.90	198,364.31
28	Ажиллагсадтай холбогдсон авлага	-	276.41
34	Бусад авлага	230,887.90	198,087.90
35	Байгууллагаас авах авлага	230,887.90	198,087.90
48	УРЬДЧИЛГАА	-	2,850,000.00
54	Урьдчилж гарсан зардал	-	2,850,000.00
60	БАРАА МАТЕРИАЛ	194,169,270.42	118,255,563.78
61	Түүхий эд материал	161,626,417.15	85,593,876.17
62	Тусгай зориулалттай материал	650,000.00	2,350,000.00
63	Эм боох материал	160,976,417.15	83,243,876.17
66	Хангамжийн материал	31,061,853.27	31,021,687.61
67	Бичиг хэргийн материал	674,952.00	735,164.00
68	Аж ахуйн материал	11,561,812.50	11,497,552.50
70	Түлш шатах тослох материал	42,661.00	11,520.00
73	Бусад хангамжийн материал	18,782,427.77	18,777,451.11
75	Мал, амьтад	1,481,000.00	1,640,000.00
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	309,726,831.51	302,013,373.28
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	309,726,831.51	302,013,373.28
108	Биет хөрөнгө	309,598,498.07	301,940,039.80
109	Барилга, байгууламж	302,188,919.00	294,727,853.00
110	Хуримтлагдсан элэгдэл	(62,391,944.94)	(70,518,783.53)
111	Авто тээврийн хэрэгсэл	154,298,052.52	183,940,909.67
112	Хуримтлагдсан элэгдэл	(108,856,084.00)	(132,651,117.58)
113	Машин, тоног төхөөрөмж	140,786,887.58	147,715,191.98
114	Хуримтлагдсан элэгдэл	(119,674,704.62)	(132,158,026.43)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,006,170.00	17,406,170.00
116	Хуримтлагдсан элэгдэл	(5,758,797.47)	(6,522,157.31)
126	Биет бус хөрөнгө	128,333.44	73,333.48
127	Програм хангамж	992,500.00	792,500.00
128	Хасагдуулга	(864,166.56)	(719,166.52)
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	504,126,989.83	423,317,301.37
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	(0.00)	-
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	504,126,989.83	423,317,301.37
215	Засгийн газрын хувь оролцоо	504,126,989.83	423,317,301.37

Говьсүмбэр аймгийн “Хүнс, хөдөө аж ахуйн газар”-ын 2017 оны санхүүгийн тайлан

216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	325,415,356.25	325,415,356.25
217	Өмч: -Төрийн өмч	325,415,356.25	325,415,356.25
223	Хуримтлагдсан үр дүн	168,975,527.81	88,165,839.35
224	Өмнөх үеийн үр дүн	168,975,527.81	168,975,527.81
225	Тайлант үеийн үр дүн	-	(80,809,688.46)
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,736,105.77	9,736,105.77
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	504,126,989.83	423,317,301.37

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Хугацаа: 17.12.31

№	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	683,516,998.52	683,188,825.01
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	375,189,724.52	297,131,817.86
77	Нийтлэг татварын бус орлого	375,189,724.52	297,131,817.86
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	375,189,724.52	296,708,825.86
82	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,004,680.00	1,566,670.00
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	373,185,044.52	295,142,155.86
92	Бусад орлого	-	422,992.00
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	164,613,400.00	215,935,127.15
112	Улсын төвлөрсөн төсвөөс	164,613,400.00	210,935,127.15
113	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	163,063,400.00	163,555,800.00
117	Хөрөнгийн санхүүжилт	1,550,000.00	47,379,327.15
119	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	143,713,874.00	170,121,880.00
136	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	5,000,000.00
137	Төсвийн захирагчдаас	-	5,000,000.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	654,146,556.61	759,388,937.08
148	УРСГАЛ ЗАРДАЛ	652,104,358.23	752,021,186.91
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	652,104,358.23	752,021,186.91
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	123,807,616.65	120,858,340.00
151	Цалин	123,807,616.65	120,858,340.00
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,852,495.55	13,944,393.42
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	8,879,281.58	9,677,561.97
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	991,647.97	1,051,715.45
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,239,560.00	921,258.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	247,910.00	208,532.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,494,096.00	2,085,326.00
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,218,272.00	8,694,404.00
165	Гэрэл цахилгааны зардал	1,039,193.00	915,568.00
166	Түлш, халаалтын зардал	7,125,895.00	6,980,566.00
167	Цэвэр, бохир усны зардал	1,053,184.00	798,270.00
170	Хангамж, бараа материалын зардал	5,296,624.00	15,436,085.00
171	Бичиг хэргийн материал	849,376.00	804,187.00
172	Тээвэр, шатахууны зардал	1,475,400.00	2,510,541.00
173	Шуудан холбоо интернетийн төлбөр	987,518.00	1,255,112.00
175	Хог хаягдал устгах, цэвэрлэх	-	56,000.00
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	1,984,330.00	10,761,245.00
178	Бараа материал актасны зардал	-	49,000.00
181	Нормативт зардал	301,498,101.19	361,917,698.50
182	Эм	301,498,101.19	361,917,698.50
185	Эд хогшил, урсгал засварын зардал	616,020.00	970,100.00
189	Урсгал засвар	616,020.00	970,100.00
190	Томилолт, зочны зардал	1,163,400.00	2,327,250.00
192	Дотоод томилолтын зардал	1,163,400.00	2,327,250.00

Говьсүмбэр аймгийн “Хүнс, хөдөө аж ахуйн газар”-ын 2017 оны санхүүгийн тайлан

194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	141,994,485.00	171,515,142.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	141,055,151.00	170,616,880.00
196	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	150,000.00	-
197	Даатгалын үйлчилгээний төлбөр	259,875.00	494,390.00
198	Тээврийн хэрэгслийн татвар	299,615.00	222,700.00
199	Тээврийн хэрэгслийн оношилгоо	60,500.00	99,000.00
201	Газрын төлбөр	169,344.00	82,172.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	54,657,343.84	56,357,773.99
210	Бараа үйлчилгээний бусад зардал	3,098,223.00	5,688,000.00
211	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	-	212,565.00
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,559,120.84	50,457,208.99
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,042,198.38	7,367,750.17
228	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	4,885,660.00
231	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,350,000.00
236	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	200,000.00	3,535,660.00
237	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,842,198.38	2,482,090.17
240	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,842,198.38	2,482,090.17
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	29,370,441.91	(76,200,112.07)
269	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	886,000.00
271	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	886,000.00
276	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	5,495,576.39
277	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	5,495,576.39
287	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-	(4,609,576.39)
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	29,370,441.91	(80,809,688.46)

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хугацаа: 17.12.31

№	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	310,994,136.00	340,244,350.00
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,375,880.00	1,566,670.00
78	Нийтлэг татварын бус орлого	2,375,880.00	1,566,670.00
82	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,375,880.00	1,566,670.00
83	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,375,880.00	1,566,670.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	308,618,256.00	338,677,680.00
111	Улсын төвлөрсөн төсвөөс	163,063,400.00	163,555,800.00
112	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	163,063,400.00	163,555,800.00
118	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	145,554,856.00	170,121,880.00
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	5,000,000.00
136	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжилт	-	5,000,000.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	311,004,136.00	339,384,350.00
148	УРСГАЛ ЗАРДАЛ	311,004,136.00	339,384,350.00
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	309,161,937.62	331,202,259.83
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	115,254,300.00	120,160,677.83
151	Үндсэн цалин	111,588,127.00	114,339,941.83
153	Унаа хоолны хөнгөлөлт	3,666,173.00	5,820,736.00
157	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	27,555,426.62	13,380,000.00
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	22,760,588.65	8,891,200.00
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	855,036.00	1,073,300.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,237,774.00	936,700.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	624,164.00	137,000.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,077,863.97	2,341,800.00
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	11,152,034.00	8,694,404.00
165	Гэрэл цахилгааны зардал	1,039,193.00	915,568.00
166	Түлш, халаалтын зардал	9,059,657.00	6,980,566.00
167	Цэвэр, бохир усны зардал	1,053,184.00	798,270.00
170	Хангамж, бараа материалын зардал	4,934,219.00	4,742,611.00
171	Бичиг хэрэг	728,075.00	609,200.00
172	Тээвэр, шатахуун	2,815,800.00	2,479,400.00
173	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,182,474.00	1,321,111.00
175	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	56,000.00
176	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	207,870.00	276,900.00
181	Нормативт зардал	1,567,790.00	692,210.00
182	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,552,390.00	624,570.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,400.00	67,640.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	617,980.00	1,635,200.00
189	Урсгал засвар	617,980.00	1,635,200.00
190	Томилот, зочны зардал	1,461,580.00	2,327,250.00
192	Дотоод албан томилот	1,461,580.00	2,327,250.00

Говьсүмбэр аймгийн “Хүнс, хөдөө аж ахуйн газар”-ын 2017 оны санхүүгийн тайлан

194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	143,231,885.00	174,365,142.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	142,036,251.00	173,466,880.00
196	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	198,000.00	-
197	Даатгалын үйлчилгээ	473,175.00	494,390.00
198	Тээврийн хэрэгслийн татвар	299,615.00	222,700.00
199	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,500.00	99,000.00
201	Газрын төлбөр	164,344.00	82,172.00
208	Бараа үйлчилгээний бусад зардал	3,386,723.00	5,204,765.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	3,174,223.00	5,000,000.00
210	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	212,500.00	204,765.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,842,198.38	8,182,090.17
225	Бусад урсгал шилжүүлэг	-	5,700,000.00
228	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,500,000.00
233	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	4,200,000.00
234	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,842,198.38	2,482,090.17
237	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,842,198.38	2,482,090.17
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(10,000.00)	860,000.00
251	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	860,000.00
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	860,000.00
263	Дотоод эх үүсвэрээр	-	860,000.00
275	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	860,000.00
278	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(860,000.00)
279	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(10,000.00)	-
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Хугацаа: 17.12.31

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0	ДАНС	511	51300	51210+51220	
2	2016 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	-	-	-	-
10	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	325,415,356.25	9,736,105.77	168,975,527.81	504,126,989.83
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	325,415,356.25	9,736,105.77	168,975,527.81	504,126,989.83
13	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
14	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(80,809,688.46)	(80,809,688.46)
18	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	325,415,356.25	9,736,105.77	88,165,839.34	423,317,301.37

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Хугацаа:17.12.31

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь	ДАНС
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-	
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	165,055,800.00	162,640,379.83	2,415,420.17	98.54	2
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	165,055,800.00	162,640,379.83	2,415,420.17	98.54	21
4	Бараа, үйлчилгээний зардал	159,355,800.00	156,940,379.83	2,415,420.17	98.48	210
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	121,389,500.00	120,160,677.83	1,228,822.17	98.99	2101
6	Үндсэн цалин	115,261,000.00	114,339,941.83	921,058.17	99.20	210101
7	Унаа, болон бусад нөхөн олговор	6,128,500.00	5,820,736.00	307,764.00	94.98	210103
8	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,380,000.00	13,380,000.00	-	100.00	2102
9	Тэтгэврийн даатгал	8,696,300.00	8,891,200.00	(194,900.00)	102.24	210201
10	Тэтгэмжийн даатгал	1,171,000.00	1,073,300.00	97,700.00	91.66	210202
11	ҮОМШӨ ний даатгал	936,700.00	936,700.00	-	100.00	210203
12	Ажилгүйдлийн даатгал	234,200.00	137,000.00	97,200.00	58.50	210204
13	Эрүүл мэндийн даатгал	2,341,800.00	2,341,800.00	-	100.00	210205
14	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,850,200.00	8,694,404.00	1,155,796.00	88.27	2103
15	Гэрэл цахилгаан	1,170,100.00	915,568.00	254,532.00	78.25	210301
16	Түлш, халаалт	8,196,400.00	6,980,566.00	1,215,834.00	85.17	210302
17	Цэвэр, бохир ус	483,700.00	798,270.00	(314,570.00)	165.03	210303
18	Хангамж, бараа материалын зардал	4,742,700.00	4,742,611.00	89.00	100.00	2104
19	Бичиг хэрэг	467,200.00	609,200.00	(142,000.00)	130.39	210401
20	Тээвэр (шатахуун)	2,714,900.00	2,479,400.00	235,500.00	91.33	210402
21	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,057,700.00	1,321,111.00	(263,411.00)	124.90	210403
22	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	85,500.00	56,000.00	29,500.00	65.50	210405
23	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	417,400.00	276,900.00	140,500.00	66.34	210406
24	Нормативт зардал	1,552,300.00	1,552,210.00	90.00	99.99	2105
25	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	1,485,000.00	1,484,570.00	430.00	99.97	210501
26	Нормын хувцас зөөлөн эдлэл	67,300.00	67,640.00	(340.00)	100.51	210503
27	Эд хогшил худалдан авах	1,635,200.00	1,635,200.00	-	100.00	2106
28	Урсгал засвар	1,635,200.00	1,635,200.00	-	100.00	210604

Говьсүмбэр аймгийн “Хүнс, хөдөө аж ахуйн газар”-ын 2017 оны санхүүгийн тайлан

29	Томилолт, зочны зардал	2,352,200.00	2,327,250.00	24,950.00	98.94	2107
30	Дотоод албан томилолт	2,352,200.00	2,327,250.00	24,950.00	98.94	210702
31	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	4,243,300.00	4,243,262.00	38.00	100.00	2108
32	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,345,000.00	3,345,000.00	-	100.00	210801
33	Даатгалын үйлчилгээ	494,400.00	494,390.00	10.00	100.00	210803
34	Тээврийн хэрэгслийн татвар	222,700.00	222,700.00	-	100.00	210804
35	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	99,000.00	-	100.00	210805
36	Газрын төлбөр	82,200.00	82,172.00	28.00	99.97	210807
37	Бараа үйлчилгээний бусад зардал	210,400.00	204,765.00	5,635.00	97.32	2201
38	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	210,400.00	204,765.00	5,635.00	97.32	210902
39	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,700,000.00	5,700,000.00	-	100.00	
40	Бусад урсгал шилжүүлэг	5,700,000.00	5,700,000.00	-	100.00	2132
41	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	1,500,000.00	-	100.00	213204
42	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	4,200,000.00	4,200,000.00	-	100.00	213209
43	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	165,055,800.00	162,640,379.83	2,415,420.17	98.54	
44	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	163,555,800.00	161,073,709.83	2,482,090.17	98.48	1310
45	Улсын төсвөөс санхүүжих	163,555,800.00	161,073,709.83	2,482,090.17	98.48	131001
46	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,500,000.00	1,566,670.00	(66,670.00)	104.44	120004
47	Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	1,566,670.00	(66,670.00)	104.44	1200041
48	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-	4
49	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-	5

2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Говьсүмбэр аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг мэдэгдье.

**Асуудал 1: АНХАН ШАТНЫ БАРИМТЫН
БҮРДЛИЙН ТАЛААР**

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №01

Илрүүлэлт

Тарилгын үлдэгдэл болон сав суулгын устгалт, вакцинжуулалтыг нотлох баримт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг зөрчиж байна.

Хариуцах ажилтан

Дарга Ч.Отгонсүрэн
Нягтлан бодогч А.Отгонтуяа

Зөвлөмж

Тарилгын үлдэгдэл болон сав суулгын устгалт, вакцинжуулалт, сургалтын зардлыг зурагжуулж, гарын үсгээр баталгаажуулж, нотлох баримтыг хангалттай бүрдүүлж байх

Эрсдэл

Нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байдал алдагдах

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

Дарга Ч.Отгонсүрэн
Нягтлан бодогч А.Отгонтуяа

Асуудал 2: Цалин хөлсний зардлын талаар

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №01

Илрүүлэлт

Цалингийн сангаас 240.0 мянган төгрөгөөр ахмадын хүлээн авалт хийж, зориулалт бусаар зарцуулжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Аудитын явцад нягтлан бодогчоос ирүүлсэн өргөдлийг шалгаж үзэхэд нягтлан бодогчийн цалинг үндэслэлгүй бууруулж, 2017 онд 252.1 мянган төгрөгийн цалин дутуу олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8, 18 дугаар зүйлийн 18.5 буюу Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтын 7 дахь заалтыг тус тус зөрчсөн байна

Хариуцах ажилтан

Дарга	Ч.Отгонсүрэн
Нягтлан бодогч	А.Отгонтуяа

Зөвлөмж

1. Цалингийн санг зориулалт бусаар зарцуулахгүй байх ба ажилчдын цалин хөлсийг үнэн зөв тогтоож байх

Эрсдэл

Нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байдал алдагдах

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

Дарга	Ч.Отгонсүрэн
Нягтлан бодогч	А.Отгонтуяа